



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-14

1. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал

4-14

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 04-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Батболд, Ж.Баясгалан, Х.Булгантуяа, Г.Ганбаатар, Б.Заяабал, Ч.Номин;

Чөлөөтэй: Ж.Ганбаатар, П.Мөнхтулга, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хэлэлцэх асуудлын дарааллын нэгдүгээрт байгаа Нийцлийн аудитын тайланг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаантай давхцаж байгаа тул хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 2

Бүгд: 16

87.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хуралд дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарыг нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Д.Пүрэвдаваа, Да.Цогтбаатар, П.Ганзориг нарын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарыг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт

явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 1
Бүгд: 19
94.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 11 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 35 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж 51,7 хувиар ирц бүрдсэн тул 2025 оны 12 сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог, Жамбын Батсуурь Жагсаалт, Пүрэвжавын Ганзориг Жагсаалт, Цэдэнпилийн Даваасүрэн 4 дүгээр тойрог, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан 1 дүгээр тойрог, Баатаржавын Мөнхсоёл Жагсаалт, Пүрэвбаатарын Мөнхтулга 1 дүгээр тойрог, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Банзрагчийн Түвшин 2 дугаар тойрог, Ганзоригийн Тэмүүлэн 1 дүгээр тойрог, Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог, Баттогтохын Чойжилсүрэн 2 дугаар тойрог, Загджавын Мэндсайхан 2 дугаар тойрог, Хуулиараа унших ёстой. Ирцийг танилцуулж дууслаа. Хуулиараа бид нар Улсын Их Хурлын гишүүнийг овог, нэр, сонгогдсон тойргоор нь танилцуулах хуулийн заалттай.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт нь Үндэсний аудитын газрын гүйцэтгэсэн улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах сэдэвт нийцлийн аудитын тайланг хэлэлцэнэ.

Хоёр дахь асуудал бусад асуудал. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг бусад асуудлаар хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая аа. Хамтарсан хуралдаан хойшилж эхэлсэнтэй холбогдоод чуулганы цаг болчихоод байна.

Тийм учраас өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлаас тэр аудитын дүгнэлтийг түр хойшлуулаад 2 дахь асуудлыг нь хэлэлцчихмээр байна. Ийм горимын санал гаргаж байна.

Д.Үүрийнтуяа: Батжаргал даргын гаргасан горимын саналын дагуу аудитын асуудлыг ирэх 7 хоногийн товд оруулахаар санал оруулъя.

Хоёр дахь асуудал буюу Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцээд явъя аа гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Цогтбаатар гишүүн, Цогтбаатар гишүүн ээ санал хураалтад бэлтгэе. Цогтбаатар гишүүн ээ санал хураах гээд байна. Бэлэн бус байгаад байх юм. Цогтбаатар гишүүн, Батсуурь дарга, Даваасүрэн гишүүн, Пүрэвдаваа гишүүн санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт. Горимын санал 16 гишүүнээс 14 гишүүн дэмжиж 87.5 хувиар дэмжигдсэн тул 2 дахь асуудалдаа орёе.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж эхэлъе.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26.3-д байнгын хороог Улсын Их Хурлаас нэг жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ гэж. Мөн хуулийн 26.4-д Байнгын хорооны даргыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэж заасан байдаг аа.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал танилцуулна.

Батжаргал даргын микрофоныг өгъе өө.

Ж.Батжаргал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна аа. Нанзадын Наранбаатар 1974 онд төрсөн, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

1992 онд Өмнөговь аймгийн 10 жилийн дунд сургууль, 1996 онд Цэргийн их сургууль, 2011 онд АНУ-ын Калифорны олон улсын их сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй.

Наранбаатар нь 1996-1998 онд Цэргийн их сургуульд багш, 1998-аас 2002 онд ТӨХ-ны мэргэжилтэн, 2002-2004 онд Өмнөговь аймгийн Татварын хэлтсийн дарга, 2004-2009 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-ын дарга, 2011-ээс 2015 онд Билигт говь хязгаарлагдан хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал, 2016-2020 онд Өмнөговь аймгийн Засаг дарга, 2020 оноос хойш Улсын Их Хурлын гишүүнээр 2 удаа сонгогдон ажиллаж байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарын парламентад ажилласан байдал, боловсрол мэдлэг туршлага зэргийг харгалзан үзэж Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна аа. Та бүгдийг дэмжиж, шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Асуувал яг микрофон дараад асуугаарай. Саналтай гишүүд алга байна. Байхгүй байна. Тийм учраас Одоо дэвшигчтэй холбоотой асуулт асуух гишүүд байвал асуулт асуух нэрсээ өгнө үү. Асуулт, үг 2 хамтдаа явах ёстой. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.4-д заасны дагуу Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж,

үг хэлж болно гэж заасан байгаа. Асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгсөн байна. Ганзориг гишүүнээр тасаллаа.

Ирцийн дарааллын дагуу Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд бүгдэд нь. Тэгээд би зүгээр асуулт гэж Үүрийнтуяа гишүүн түр Төсвийн байнгын хорооны хуралдааны даргалагч хийсэн. Тэгээд цаашдаа батлагдах юм байх гэсэн хүлээлттэй байсан. Наранбаатар гишүүнийг дэмжиж байна. Тэгэхдээ би өөрөө эмэгтэй хүн гэдэг шиг ер нь бол энэ Төсвийн байнгын хороонд дийлэнх нь эрэгтэйчүүд байдаг. Нөгөө утгаараа орон даяар од 2028 оноос квотын асуудал 40 рүүгээ орж байгаа гэх мэт. Ер нь жендерийн тэгш байдал шийдвэр гаргах түвшинд улс төрийн оролцоонд эмэгтэйчүүдээ дэмжье гэдэг дээр би өөрөө өнгөрсөн 4 жил нэлээн манлайлж ажилласан хүний хувьд Үүрийнтуяагаа хамгийн наад зах нь энэ хүйсийн давуу байдал олгооч ээ гэдэг утгаар нь уг нь дэмжмээр байсан юм. Энийгээ зориуд хэлчихье гэж бодож байна. Тэгээд гишүүддээ нэмж мэдээлэхэд сая би хуваалцсан нэг тайлан байгаа. Тэгээд энэ 7 хоногт 12 сарын 10 хүртэл 14 хоног жендер бэйсед вайланс гээд жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг ийм юу явж байгаа. 14 хоногийн аян. Тэрэнтэй ч холбогдуулаад зориуд хэлчхэж байгаа шүү.

Баярлалаа. Том асуудлыг товчхон илэрхийлчихье.

Д.Үүрийнтуяа: Мөнхсоёл гишүүн санал хэллээ. Пүрэвдаваа гишүүний микрофоныг нээе.

Д.Пүрэвдаваа: Хэд хэдэн асуудал байна аа. Төсвийн байнгын хорооны дарга гэдэг бол маш хариуцлагатай албан тушаал. Ялангуяа Улсын Их Хурлын төсөвтэй холбоотой, мөнгөний бодлоготой холбоотой төсвийн хүрээний мэдэгдэл, макро эдийн засгийн асуудалтай холбоотой нийт улсын өрийн бодлоготой холбоотой асуудлуудыг зангидаж авч явдаг, хуралд оруулдаг мэргэжлийн маш хариуцлагатай байх тийм шаардлагыг тавигддаг юм аа. Тийм учраас нэр дэвшигчээс нэг хэд хэдэн асуулт асуумаар байна. Энэ дээр ямар байр суурьтай байдаг юм. Энгийн жишээгээр асуухад одоо энэ та бүхэн маань ЖДҮ-ийн сангаас авхуулаад МАН удаа дараа энэ сантай холбоотой олон асуудлууд үүсэж байсан. Дараа нь энэ төсвийн гүйцэтгэл дээр энэ аудитын газраас маш олон зөрчлүүд дүгнэгдээд хянагдаад ороод ирдэг. Тэгээд таны өмнөх Байнгын хорооны дарга ажлын хэсгийн дарга нэртэй хүмүүс хууль зөрчөөд, дэг зөрчөөд, тэгээд Төсвийн байнгын хороон дээр хэлэлц гээд орж ирж байгаа асуудлыг зөвхөн санал хураалтаар хааж явдаг. Энэ асуудал дээр та ямар байр суурьтай байна вэ?

Та энэ хуралдааны бүүр тэмдэглэлд тусгуулахын тулд та яг дэг сахиулна гэдэг дээрээ 100 хувь байх уу? Эсвэл сая өнгөрсөн удаагийнх шиг улс төрийн намууд зөвшилцөлд хүрэхээр зэрэг дэгээ зөрчөөд явчих тийм одоо хандлага ийм зүйл дээр та өөрийнхөө байр суурийг энэ тэмдэглэлд үлдээгээд хариулах нь зүйтэй байх аа гэж бодож байна. Тэгээд тодруулна аа.

Д.Үүрийнтуяа: Наранбаатар гишүүн хариулъя.

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Тэгэхээр Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энэ сангууд Засгийн газрын сангууд ордог. Тэгээд өнгөрсөн хугацаанд Засгийн газрын сангуудтай холбоотой олон асуудлууд үүссэн нь нийгэмд ил тод болсон. ЖДҮ-ийн сан, Боловсролын зээлийн сан гээд одоо асуудлууд үүссэн. Зарим сангуудтай холбоотойгоор Улсын Их Хурлаас хянан шалгах одоо түр хор байгуулагдаж байсан, нийтийн сонсгол хийж байсан. Мөн одоо сангуудтай холбоотой гарсан тодорхой зөрчил, хууль зөрчсөн асуудлуудыг бас нийгэмд гаргаж ирж зарим нь одоо хууль хяналтын байгууллагуудаар ингээд яваад ингээд асуудлууд нь нэлээд ил тод болж байгаа.

Сүүлийн үед энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаас хойш бол нэлээд сангуудын үйл ажиллагаа нийтэд ил тод болж байгаа байх аа гэж бодож байгаа. Тэгээд цаашдаа бол энэ сангуудын төвлөрүүлэлт, зарцуулалт дээр бол Төсвийн байнгын хорооноос, Байнгын хорооны даргын хувьд бас хяналт тавьж ажиллах, Байнгын хороон дээр сангуудын мэдээллийг ээлж дараатай оруулж ирж гишүүдэд иргэдийн мэдэх эрхийг хангах ажлыг хийе гэсэн. Ийм бодолтой байна сангуудын хувьд бол хэрвээ болбол.

Тийм төсвийн гүйцэтгэлтэй холбоотой аудит хийж байнгын хороо Улсын Их Хуралд танилцуулдаг. Тэгээд энэ дээр олон л одоо өнгөрсөн хугацаанд зөрчил дутагдлууд гардаг аа. Тэгээд аудитын байгууллагуудаас тодорхой зөвлөмжүүдийг хүргүүлдэг, дүгнэлт гаргадаг. Тэгээд энэ дээр тодорхой ажлуудыг хийх ёстой. Харамсалтай нь бас тодорхой энэ аудитын зөвлөмжийн дагуу хийсэн ажил тааруу байгаа байх гэж бодож байгаа. Яагаад гэвэл жил болгон л гардаг алдаа дутагдлууд зөрчлүүд гараад байгаа учраас энэ дээр цаашдаа анхааръя. Мөн одоо Байнгын хорооны гишүүдийн энэ Байнгын хорооны хурал дээр үгээ хэлэх, асуулт асуух заагдсан дэгийн тухай хуулийн дагуу энэ гишүүдийн эрхээ эдлэх дээр нь онцгой анхаарч ажиллана аа гэсэн ийм бодолтой байна. Хэрвээ одоо Байнгын хороон дарга болбол.

Д.Үүрийнтуяа: Тодруулъя. Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Хариултыг бүрэн гүйцэд авсангүй.

Нэгдүгээрт бүүр тодорхой асуучихъя. Жил болгон энэ өөрийнхөө төсөвт тааруулаад улс төржсөн энэ төсвийн хүрээний мэдэгдэл гээд энэ хүрээ хязгаарыг төсөв болгонд тааруулж өөрчилдөг энэ асуудлыг та яг ямар үе шаттайгаар яаж зохицуулах юм бэ гэдгээ тодорхой хариулт.

Хоёрдугаарт. Энэ аудитаар ордоггүй, аудитаар хянагддаггүй Төсвийн тухай хууль зөрчөөд батлагдсан энэ төсвүүдээ яах юм? Үүрийнтуяа даргын ахалсан ажлын хэсэг жишээгээр 1 сарын 1-ээс НӨАТ-ын буцаалтыг олгоно гээд 300 гаруй тэрбум төгрөг олгоно гэж байснаа тэрийгээ 10 сараар ухраасан байдлыг тэр нь аль төсөв дээр тавигдсан нь тодорхойгүй ийм үйл явц явсан, хаагуур хянагдсан юм? Энэ дээр та ямар байр суурьтай үйл ажиллагаа явуулах юм?

Д.Үүрийнтуяа: Нэмж өгье. Пүрэвдаваа гишүүнд нэг минут нэмж өгье.

Д.Пүрэвдаваа: Тийм. Мөнгөний бодлогын талаар өнөө өнөөдөр валютын нөөц ихэссэн л гээд байдаг. Төгрөгийн ханш унаад байдаг. Тэгээд мөнгөний бодлого орж ирэхдээ энэ төсвийн хүрээтэйгээ болон батлагдаж байгаа төсөвтэйгөө дээрээс

нь 5 жилийн энэ зорилттойг уялдаж байгаа эсэх дээр таны байр суурь. Макро эдийн засгийн өнөөгийн үзүүлэлт. Ер нь та тоймоор нэг хариулчихад өнөөдөр Монгол Улс чөлөөт зах зээл буюу эрэлт нийлүүлэлтээрээ явж байгаа юу, Эсвэл төрийн хяналттай зах зээл явж байгаа юу гэдэг дээр та нэг хариулт өгчих.

Д.Үүрийнтуяа: Нэр дэвшигч Наранбаатар гишүүний микрофоныг өгье. Хариулъя.

Н.Наранбаатар: Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой төсөв батлагдах болгонд дагаж өөрчилдөг асуудлыг бид нар гишүүд их ярьдаг аа. Ер нь бол бид нар хуулиа л дагаж явах ёстой юм. Төсвийн хүрээний мэдэгдлийг ингээд төсөв өргөн барих болгон дагуулж өөрчлөөд тэр тухайн жилийн төсөвтөө тохируулаад нааш нь цааш нь од хөдөлгөөд байдаг бол зохисгүй асуудал. Тийм учраас цаашдаа төсвийн хүрээний мэдэгдэлдээ багтааж л одоо төсвөө хэлэлцэж явдаг. Ийм байх ёстой гэж үзэж байгаа юм аа. Аудитаар одоо ороод зөвлөмжүүд дүгнэлтүүд гарчихсан асуудлууд зөндөө байдаг. Тухайлбал өнөөдөр бид нар уг нь аудитын одоо дүгнэлт, хөрөнгө оруулалтад хийсэн төсөв нь тодорхой хэмжээгээр өссөн энэ асуудлуудаар аудит хийсэн дүнг одоо сонсох байсан. Үүнийг ирэх 7 хоногт үргэлжлүүлээд хэлэлцэхээр хойшлуулсан.

Д.Үүрийнтуяа: Наранбаатар гишүүн гүйцээж хариулъя.

Н.Наранбаатар: Тэрэн дээр одоо тодорхой асуудлууд яригдаад явах байх аа гэж бодож байгаа. Цаашдаа бид нар энэ сахилга хариуцлагаа сайжруулах энэ зураг төсөв нь одоо тодорхой болоогүй байхад төсөвт тусгаад явдаг. Тэр нь төсөвт өртөг нь нэмэгддэг барьдаг гээд олон асуудлууд байгаа. Эд нар ер нь өөрсдөөсөө эхлэх ёстой юм байна лээ. Тийм зүйлүүдийг бид нар батлахгүй байх ёстой юм байна лээ.

Дараа нь Мөнгөний бодлого чөлөөт зах зээлтэй холбоотой ер нь бол төр тодорхой хэмжээгээр энэ оролцох ёстой. Одоо ялангуяа энэ үнийн бодлого, мөнгөний бодлого дээр бид нар оролцож зах зээлийг зарим зүйлүүдийг тохируулж явах ёстой. Мөн д зарим зүйлүүд дээр төр хамаагүй оролцож болохгүй ээ, зах зээлийнхээ зарчмаар явах зүйлүүд ч байгаа. Тэгээд ийм асуудлуудыг бол тухайн үед нь нөхцөл байдалтайгаа тохируулаад ингээд одоо шийдвэр гаргаад явна аа гэсэн ийм бодолтой байна.

Д.Үүрийнтуяа: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Энэ МАН-ын зодоон дуусчихсан гэж ойлгох юм уу? Уг нь сая Үүрийнтуяа даргыг дарга болох гэж байна гэж бодоод явж байсан чинь одоо болохоор өөр Наранбаатар гишүүний нэр ороод ирэх юм. Тэгээд ямар сургууль төгсчихсөн гэсэн бэ? Яг мэргэжлийнх нь талаас бид нэг асуулт асуух гэсэн юм. Тэрийгээ нэг хэлээд өгөөрэй. Тэгээд мөнгөний бодлого гээд яриад байна. Мөнгөний бодлогыг бол Улсын Их Хурал тавиад туучихсан шүү дээ. Бараг хэлэлцээгүй шахуу Монголбанкийг ёстой нэг нялх хүүхэд бүүвэйлж байгаа юм шиг бүүвэйлж өгөөд гаргаад явуулчихсан. Төсөв, МАН-ын зодоон 2 хэрүүл хийж байх хооронд мөнгөний бодлогыг тавиад туучихсан. Ямар ч ажил хийгээгүй. Одоо араас нь Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшиж байгаа гишүүн та мөнгөний бодлого дээр одоо анхаарч ажиллана гэж тэрэн шиг үлгэр байхгүй. Нэг жил өнгөрчихсөн шүү дээ одоо. Тэгэхээр хэдүүлээ тэр

төсвийн бодлого дээрээ л ярих ёстой. Төсвийн байнгын хороо бол урсгал зардлаа цаашид өсгөхгүй байх ямар бодлого баримтлах юм, Энэ төр одоо энэ нэг ямар ч хэрэггүй нэгхэн тэрбум төгрөгийн төсөвт оруулах нэмэлтээр энэ ТӨК-удаасаа яаж салах юм? Хэзээ хувьчлах юм? Энэн дээр яаж бодлого гаргаж ажиллах юм.

Дээрээс нь гадаадын зээл тусламжтай холбоотой асуудлууд чинь дандаа Монголд ашиггүй хувилбараараа гэрээнүүд нь хийгддэг. Жишээ ярих юм бол одоо энэ 10 аймагт хэрэгжиж байгаа дулааны станцууд Баянхонгор, Өвөрхангай аймгуудад хэрэгжиж байгаа дулааны станцууд нь барилга нь таг гацаад зогсчихсон Солонгосын Эксим банк Солонгосоос одоо төсөл хэрэгжүүлэгчээр шалгаруулж ирсэн. Гэтэл нөгөө компани нь цаанаа дампуурчихсан. Одоо болтол Монголын тал хүү төлөөд явж байгаа. Хүү зогсох ёстой шүү дээ уг нь. Солонгосын тал Солонгосоос сонгон шалгаруулалтаа шалгаруулчихаад байхад чинь Монгол хүү төлөөд байна. Эдгээрийг зогсоох гээд энэ зарчмын асуудлуудыг л тантай ярих ёстой байх аа. Тэгээд та энэ төсвийн бодлого дээр ямархуу бодлого баримталж ажиллах юм бэ гэдгээ нэг хэлээч? Тэгээд энэ МАН-ын бүлгийн дарга Монголын Монгол Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалууд дээр буюу одоо СЗХ-ны орон тооны бус гишүүн дээр Төсвийн байнгын хорооноос 3, 4 хүн 3, 4 удаа нэр дэвшээд унаж байхад маш олон материал, маш орон олон сонсгол хийсэн мөртөө одоо яагаад байнга Байнгын хорооных даргыг бид нарт бүүр анкетыг нь ч тараахгүйгээр хийж байгаа юм. Бид нар анкетынх нь мэдээллийг гүүгдэж олж авах юм уу? Яагаад ингээд хүч түрэх гээд байгаа юм? Танай намын зодоон дуусчихсан бол ядахдаа наад анкетаа тарааж болдоггүй юм уу дарга аа?

Иймэрхүү асуултууд дээр хариулт авъя.

Д.Үүрийнтуяа: Бүлгийн дарга Батжаргал дарга хариулт өгье.

Ж.Батжаргал: МАН-ын бүлэгт зодоон талцлын тухай асуудал байхгүй. Тодорхой цаг хугацаанд, тодорхой асуудал дээр байр суурийн зөрөөнүүд байсан үнэн. Тэрүүнийгээ бид энэ ард түмний энэ их том дэмжлэг үүрүүлсэн ачаа хариуцлагаа ухамсарлаж энэ улс орны тогтвортой хөгжил иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхтэй холбоотой бодлогын зорилт хангахад бүлэг бодлого, үйл ажиллагаа, байр сууриа нэгтгээд ажиллаж байгаа гэдгийг зориуд хэлмээр байна.

Төсвийн байнгын хорооны даргад эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй. Монгол Улсын ТӨХ-нд мөн татварын байгууллагад Монголын эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэдэг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн даргаар ажиллаж байсан тодорхой хэмжээний эдийн засаг, төсвийн чадамж, мэргэжил боловсролынх одоо нөхцөлийг хангасан ийм гишүүнээ нэр дэвшүүлж байгаа, нэг.

Хоёрдугаарт энэ Их Хурлын үндсэн бүтцийн байгууллагуудад энэ парламентад ажилласан байдал, мэргэжил, боловсрол, чадвар зэргийг нь харгалзан үзэж бид удирдлагуудыг нь томилж байх ёстой. Ингэж байж энэ төрийн ажлын бодлого залгамж чанар шинэчлэл энэ бүх юм хангагдаж явах ёстой юм аа. Энэ үүднээс Нанзадын Наранбаатарыг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн гэдгийг зориуд хэлмээр байна аа.

Д.Үүрийнтуяа: Нэр дэвшигч Наранбаатар гишүүн асуултад хариулья.

Н.Наранбаатар: Төгссөн сургуулийн хувьд бол 1996 онд Цэргийн их сургуулийн Ар тал эдийн засгийн тэнхимийг төгссөн. Цэргийн эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. Төгсөөд Төрийн сургуульдаа багш хийсэн. Мөн ТӨХ-нд мэргэжилтэн, мөн татварын байгууллагад татварын хэлтсийн дарга мөн тэгээд төсвийн ерөнхийлөн захирагч гээд ийм ажлуудыг Улсын Их Хуралд гээд одоо 5 дахь жилдээ Улсын Их Хуралд ажиллаж байна аа. Урсгал зардлын хувьд бол цаашдаа бид нар урсгал зардлыг дээр анхаарч жил болгон төсөв батлахдаа аль болохоор урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх ёстой. Тэгэхдээ автоматаар бас одоо шинээр сургууль, цэцэрлэг эмнэлгүүд байгуулагдахад зайлшгүй урсгал зардлууд нэмэгдэж явж байдаг. Тэгээд энэ дээр урсгал зардлыг өсгөхгүй байх дээр анхаарах ёстой юм байгаа.

Д.Үүрийнтуяа: Наранбаатар гишүүн гүйцээгээд хариулъя.

Н.Наранбаатар: Тэгээд ТӨК-удыг хувьчлах үр ашгийг сайжруулах дээр д 3Г-аас тодорхой ажлын хэсэг байгуулагдаад, тодорхой арга хэмжээнүүд аваад ингээд явж байгаа. Гаднын зээл тусламж дээр бас бид нар анхаарахгүй бол гаднын зээл тусламж болгоныг бага хүүтэй үр ашигтай гээд аваад байх тийм шаардлага байхгүй юм байна лээ. Тухайлбал тэр дулааны станцууд, махны үйлдвэрүүд гээд бидэнд харин ч одоо зээл тусламж биш нэмээд өр дарамт болохоор зүйлүүд байгаа юм билээ. Үүнийг бол дараа дараагийнх дээр анхаарч явах ёстой юм билээ.

Д.Үүрийнтуяа: Тодруулъя гэнэ. Цогтбаатар гишүүнд тодруулъя.

Да.Цогтбаатар: Өмнө бид нар ярьж байхад бол Улсын Их Хурал, Засгийн газар бүсчилсэн байдлаар хөгжих ёстой гэж нэлээн ярьсан. Тэгээд энэ асуудлаа ярих гэхээр одоо бид нар Төсвийн байнгын хорооны дарга ч Өмнөговь аймгаас одоо мэргэжилдээ сайн гээд орж ирдэг. Эдийн засгийн байнгын хороон дээр ч орж ирдэг. Тэгэхээр бид нарын нөгөө бүсчилсэн хөгжил хүн төвтэй байх чинь Өмнөговьд л бүх асуудал шийдэгдэх ёстой юм шигээр ойлгогдож байна шүү. Энийг бас нэг Улсын Их Хурал, МАН-ын бүлэг анхаарвал зүгээр болов уу гэж бодож байна. Тэгээд Төсвийн байнгын хороонд Сангийн яам харьяалагдаж байгаа. Сангийн яаманд Төрийн банк харьяалагдаж байгаа. Төрийн банкны захирал нь Цагаан байрны даргын үеэл байгаа. Төрөөс төрж байгаа энэ тэрбумтнуудтайгаа хэзээ тэмцэх юм бэ? Та од энэ Төсвийн байнгын хорооны дарга болсноор энэ Төрийн банктэй холбоотой энэ завхралаа цэгцэлж чадах уу?

Д.Үүрийнтуяа: Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Төрийн банкны удирдлагуудын хувьд одоо над мэдээлэл алга аа. Хэрвээ одоо Төсвийн байнгын хорооны даргаар томилогдсон нөхцөлд бол энэ Сангийн яам, тэгээд л гааль, татвар, Төрийн банк гээд эдгээр үйл ажиллагаатай танилцана. Хамгийн эхний ажил бол энэ жилийн төсвийн гүйцэтгэл, Эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа талаар Байнгын хороон дээр бид сонсоод ингээд ажлаа цааш нь эхлээд явах байх. Тэгээд харьяа байгууллагуудтайгаа танилцаад явах байх аа гэж бодож байгаа. Одоо бол нарийн мэдээлэл алга.

Д.Үүрийнтуяа: Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Төсвийн байнгын хороо бол маш чухал Байнгын хороо. Тэр тусмаа Монгол Улсын төсөв боловсруулах, хэлэлцэхэд хяналт тавьж тодорхой санал дүгнэлт гаргадаг, санал оруулдаг.

Төсвийн гүйцэтгэлд хяналт тавьдаг, төсвийн тогтвортой байдлын бодлогыг хянаж хэлэлцдэг гээд олон чухал ийм үүрэгтэй Байнгын хороо. Тэгээд манай Монгол Улсын төсөв бүтцээрээ гажуудаж, төсөв мөнгөний бодлого бол олон засаж залруулах асуудлуудтай болсон. Тэгэхээр энэ дээр бол Төсвийн байнгын хороо тэр тусмаа Төсвийн байнгын хорооны дарга бол бас манлайлал үзүүлж ажиллахгүй бол энэ гажуудлууд засагдахгүй ээ. Тэгэхээр би яах вэ Наранбаатар нэр дэвшигчийг дэмжиж байна. Тэгэхдээ ер нь одоо энэ намын бүлгүүдээс оруулж ирэхдээ улс төрийн туршлага нь одоо илүү юм аа ч гэдэг юм уу гэж тодорхойлж байх шиг байна.

Тэрнээсээ гадна энэ дээр чинь макро эдийн засгийн бодлогын асуудлууд төсөв мөнгөний бодлогын асуудлууд гээд илүү мэргэжлийн байдал, мэргэшсэн байдал их чухал аа. Бид нар одоо нэг улс төрийн туршлагыг нь харж ерөөсөө энэ чухал чухал мэргэжлийн Засгийн газар ч байна уу, Их Хурлын бүтцийн байгууллагууд ч байна уу тэрний харьяа байгууллагууд ч байна уу томилгоо хийсээр байгаад энэ том гажуудлуудын суурь болдог гэдгийг энд хэлмээр байна. Тэгээд тухайлбал одоо ингээд намын бүлгээсээ томилогдчихоор Байнгын хороон дарга нар зүгээр төсвийн ажлын хэсэг байгуулахдаа хүртэл цаанаасаа хэнийгээ оруулах вэ, хэнийгээ оруулахгүй вэ, засгаас өргөн барьсан төсвийг дэмжих үү гээд ингээд зохиол зохион байгуулаад явчихдаг. 2026 оны төсвийн ажлын хэсэг байгуулахад тухайлбал одоо намайг оруулаагүй. Түвшин гишүүнийг оруулаагүй АН-ын. Тэмүүлэн гишүүн ороогүй гээд ингээд саналуудаа гаргаад явъя гэхээр оруулдаггүй. Тэгээд бүлэг дээрээ нэгдсэн байр суурьтай байгаа гээд нөгөө төсөв нь шууд ийм бэлэн ингээд ногоон гэрлээр яваад байх ийм энэ нь гажуудлууд үүсгээд байх асуудлууд үүсдэгийг анхаарч ажиллаарай гэж хүсмээр байна.

Хоёрт энэ төсөв дээр энэ жил болгоны төсөв хэлэлцэхэд л нэг их асуудлууд гарч ирдэг, улс төрждөг. Гүйцэтгэлээ бид нар дандаа орхиж ирсэн. Одоо өнгөрсөн оны төсвийн гүйцэтгэл дээр 9 их наядын зөрчил илэрсэн гээд ЗГХЭГ-ын сайд Бямбацогт мэдэгдсэн. Тэгээд л таг. Тэрэн дээр одоо цаашаа ямар арга хэмжээ авах гэж байгаа юм.

Тэгээд жил болгоны төсвөө батлаад өгчихдөг. Засгийн газар нь тэрийгээ яаж зарцуулж, яаж зөрчил илэрч асуудал үүсгэж байгааг нь ингээд тоодоггүй хаяад л дараагийнхаа төсвийг батлаад л яваад байдаг ийм байдалтай байж болохгүй. Тэгэхээр энэ төсвийн гүйцэтгэлд хяналт тавьдаг төсвийн тогтвортой байдлын бодлогыг та маш сайн хэрэгжүүлнэ ээ гэж байна. Энийг бол сайшааж дэмжиж хүлээж авна аа. Тэгээд энэ чиглэлүүд дээрээ анхаарч ажиллаарай гэж хүсье ээ. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Ганзориг гишүүн үг хэллээ. Асуулт биш гэж ойлголоо.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүний хувиар миний би саналаа хэлье, үгээ хэлье. Саяын асуулт дунд одоо Пүрэвдаваа гишүүний асуулт дунд НӨАТ-ын буцаалттай холбоотой төсөвт суусан асуудлаар асуудал хөндөгдсөн учраас тодорхой тайлбар хэлчих нь зөв болов уу гэж бодож байна. Миний бие Улсын Их Хурлын одоо дэргэд

байгуулсан төсөв дагасан хууль тогтоомжийн ажлын хэсгийг 2026 оны төсвийг одоо дагасан ажлын хэсгийг ахалсан. Энэ дээр НӨАТ-ын буцаалтыг 5 хувийг хэрэгжих хугацааг 2026 оны 10 сарын 1-ээс хэрэгжихээр тооцсон байгаа. Энд бол ямар нэгэн хоёрдмол ойлгомжгүй зүйл байхгүй. Өөрөөр хэлбэл мөнгөн урсгалаар 2027 онд нөлөөлнө өө гэсэн үг. 2026 онд нөлөөлөхгүй ээ гэсэн үг. Гол шалтгааныг та бүхэн мэдэж байгаа. Засгийн газар анх өргөн барихдаа 2026 онд мөнгөн урсгал нь нөлөөлөхөөр тооцож оруулж ирсэн боловчиг Засгийн газрын төсөөлөөгүй бас ажилчдын цалин хөлс нэмэх, эрүүл мэнд, боловсролын салбарын суудлууд хөндөгдсөн учраас мөнгөн урсгалдаа одоо орон зай гаргаж энэ хуулийн хэрэгжилтийг 10 сарын 1 болгон Улсын Их Хурлын байнга хороо, дэмжиж нэгдсэн чуулганаар хууль батлагдсан.

Тийм учраас энд хоёрдмол ойлгомжгүй зүйл байхгүй шүү гэдгийг тодруулаад хэлчихье ээ гэж бодож байна аа.

Улсын Их Хурлын тухай хуулийн 26.4-д заасны дагуу одоо Улсын Их Хуралд сонгогдсон ажилласан туршлага, аймаг, орон нутаг удирдаж байсан туршлагыг нь харгалзаж МАН-аас одоо манай Наранбаатар гишүүнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж оруулж ирж байгаа. Тэгээд миний хувьд одоо Улсын Их Хуралд ажилласан дадлага туршлага аймаг орон нутаг удирдаж байсан энэ дадлага туршлагыг дэмжиж энэ шийдвэрийг нэр дэвшилтийг дэмжиж байгаа.

Тэгээд өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын даргын захирамжаар Төсвийн байнгын хороог дараагийн даргыг томилогдох хүртэл хугацаанд 20 хоног ахалж ажиллалаа. Энэ хугацаанд хамтран ажиллаж дэмжиж байсан эрхэм гишүүддээ талархлаа илэрхийлье.

Мөн жендерийн хувьд болон одоо мэргэжлийн хүний хувьд энэ ажлыг хийх боломжтой гэж үнэлж дэмжсэн эрхэм гишүүддээ Мөнхсоёл гишүүнд талархлаа илэрхийлье ээ.

Ингээд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж дууслаа. Дэгээрээ хамт юм байна лээ уучлаарай, хамт юм байна лээ шүү дэг нь.

Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явагдана.

Тийм учраас эрхэм гишүүд санал хураалтад бэлтгэе.

Батсуурь гишүүн. Батбаяр гишүүнийх ороогүй харагдаад байна. Даваасүрэн гишүүн, Чойжилсүрэн сайд. Харин та хэдийнх л ороогүй харагдаад байх юм. Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

19 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 94.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлт Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна. Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяад танилцуулна.

Байнгын хорооны нэр даргад нэр даргад нэр дэвших тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Өнөөдрийн чуулган юу хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

11.08 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА